

### Журам **шинэчлэн** батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам”-ыг хавсралт ёсоор **шинэчлэн** баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Улсын хилээр нэвтрэх эрхийг тйдгэлзүүлсэн иргэдийн бїртгэл, хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” байгууллагын даргын 2015 оны А/118 дугаар тушаалын 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Н.Баянмөнх/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Д.МӨРӨН

ГАДААДЫН ИРГЭНИЙГ МОНГОЛ УЛСААС ГАРАХЫГ  
ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ГАРАХЫГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ  
ШИЙДВЭР ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гадаадын иргэнийг гарахыг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр шийтгэх, шийхийн шийдвэр гийцэтгэх болон прокурорын байгууллага /цаашид “эрх бүхий байгууллага” гэх/-аас ирүүлсэн саналыг үндэслэн гаргана.

Хоёр. Гарахыг түдгэлзүүлэх шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх

2.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн **34.3** дахь хэсэгт зааснаар гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга /цаашид “байгууллагын дарга” гэх/ нь эрх бүхий байгууллагын албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн гадаадын иргэнийг **Монгол Улсаас** гарахыг түдгэлзүүлэх шийдвэр гаргана.

2.2. Байгууллагын дарга нь гадаадын иргэнийг гарахыг түдгэлзүүлэх шийдвэр гаргахдаа уг гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичигт бичигдсэн латин галиг бүхий овог нэр, төрсөн он, сар, өдөр, иргэншил, паспорт, түүнийг орлох баримт бичгийн дугаар, тус улсаас гарахыг түдгэлзүүлэх зайлшгүй нөхцөл зэргийг тусгасан эрх бүхий байгууллагын санал бүхий албан бичгийг үндэслэн гаргана.

2.3. Эрүүгийн гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан гадаадын иргэнийг гарахыг түдгэлзүүлэх тухай санал нь тухайн хэрэгт хяналт тавьж буй прокурорын саналыг үндэслэн дээд шатны прокурорын эрүүгийн хэргийн дугаар, **Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэгт холбогдуулан шалгаж буй тухай**, хариуцах албан хаагчийн нэр, албан тушаал, харилцах утасны дугаарыг тодорхой дурдсан албан бичиг байна.

**2.4. Иргэний хэрэг маргаанд гадаадын иргэнийг гарахыг түдгэлзүүлэх тухай санал нь шийхээс шийгчийн захирамж, албан бичиг, шийхийн шийдвэр гийцэтгэх байгууллагаас албан бичиг байна.**

2.5. Гарахыг түдгэлзүүлэх шийдвэр нь уг шийдвэрийг **хичингй болгох** тухай шийдвэр гарах хүртэл хүчинтэй байх бөгөөд гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн санд хугацаагүйгээр бүртгэнэ.

2.6. Гадаадын иргэнийг гарахыг түдгэлзүүлэх шийдвэр гарсан даруйд хилийн хориг хариуцсан албан хаагч нь гарахыг түдгэлзүүлсэн иргэний талаарх мэдээллийг нэгдсэн санд бүртгэж, **шийдвэр гарснаас хойш 24 цагийн дотор** гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутаг дахь хилийн боомтуудад албан бичгээр мэдэгдэнэ.

2.7. **Энэхүү журмын 2.1-д заасан шийдвэр гарсан талаар** гадаадын иргэнийг гарахыг түдгэлзүүлэх санал ирүүлсэн байгууллагад ажлын 3 өдөрт багтаан албан бичгээр мэдэгдэнэ.

2.8. Амралтын болон ажлын бус цагаар хойшлуулшгүй тохиолдолд гадаадын иргэнийг гарахыг түдгэлзүүлэх тухай саналыг эрх бйхий байгууллагаас ирүүлбэл **хилээр гарахыг тйдгэлзййлэх бйртгэлийг** нэн даруй гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, дараагийн ажлын едөрт багтаан **хилээр гарахыг түдгэлзййлэх** саналыг тухайн байгууллагаас нөхөн авч, шийдвэрийг гаргана.

2.9. Гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэлгүй буцааж, **паспорт, тйинийг орлох баримт бичгийг тйр хураан авна.**

2.10. **Хилийн хориг хариуцсан албан хаагч хил дээрээс буцаасан** гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг гарахыг түдгэлзүүлэх санал ирүүлсэн байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

2.11. Гарахыг тйдгэлзййлэх санал ирййлсэн байгууллага нь гадаадын иргэний мэдээллийг йнэн зөв ирййлэх ййргийг хйлээх бөгөөд **алдаатай** мэдээллээс ййсэх хариуцлагыг бйрэн хариуцана.

Гурав. Гарахыг түдгэлзүүлэх шийдвэрийг **тйр** цуцлах

3.1. Гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн нь албан болон хувийн зайлшгүй шаардлагаар гадаад улсад зорчих тохиолдолд санал ирүүлсэн байгууллага, эсхүл дээд шатны буюу хяналт тавих эрх бүхий байгууллагаас ирсэн албан бичгийг үндэслэн гарахыг тйдгэлзййлэх шийдвэрийг тйр цуцлах тухай шийдвэрийг байгууллагын дарга гаргана.

3.2. Гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн Монгол Улсын хилээр эргэн орж ирсэн үеэс эхлэн гарахыг түдгэлзүүлснийг түр цуцалсан шийдвэрийг **хичингй болгож, эрх бйхий байгууллагын албан бичгээр ирййлсэн саналыг йндэслэн байгууллагын дарга хилээр гарахыг тйдгэлзййлсэн шийдвэрийг дахин гаргаж, хориг хариуцсан албан хаагч гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн санд бйртгэнэ.**

Дөрөв. Гарахыг түдгэлзүүлэх шийдвэрийг хүчингй болгох

4.1. Байгууллагын дарга нь гадаадын иргэнийг хилээр гарахыг түдгэлзүүлэх тухай йндэслэл арилсан талаар эрх бйхий байгууллагаас албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн хилээр гарахыг түдгэлзүүлэх шийдвэрийг хүчингй болгох тухай шийдвэр гаргана.

4.2. Энэ журмын 4.1-д заасан шийдвэр гармагц гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн сангаас хасалт хийж, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутаг дахь хилийн боомтуудад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

4.3. **Эрх бйхий байгууллага** гадаадын иргэнийг хилээр гарахыг түдгэлзүүлэх шийдвэрийг цуцлах саналаа мэдэгдээгййн улмаас уг гадаадын иргэнд учирсан хохирлыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцахгй бегеэд энэ талаар гарахыг тйдгэлзййлэх санал ирййлсэн байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ.

4.4. Гадаадын иргэний хилээр гарахыг түдгэлзүүлэх шийдвэр хйчинтэй байх хугацаанд визийн хугацаа хэтэрсэн нь гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах үндэслэл болохгй.

Тав. Бусад

5.1. Монгол Улсаас гарахыг тйдгэлзййлсэн гадаадын иргэний талаар холбогдох хууль хяналтын байгууллага хйсэлт гаргавал тухай бйр лавлагаа, мэдээллээр ханган ажиллана.

5.2. Хилээр гарахыг тйдгэлзййлсэн гадаадын иргэний мэдээллийг улирал тутам байгууллагын даргад илтгэх хуудсаар танилцуулна.

5.3. Энэ журмын хэрэгжилтийн явцад гарсан гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан ергедэл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

-----oOo-----